

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/01

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны санхүүгийн
тайлангийн талаар
дүгнэлт гаргах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйл, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АХ-26/01 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн Компанийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн аудит хийж, гаргасан хараат бус аудитор “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасан тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын 1-т заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Ж.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/02

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны
тайлангийн талаар
дүгнэлт батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 16.5 (арван зургаа аравны тав) төгрөгөөр тогтоож, 2025 оны цэвэр ашгийн 30.4 (гуч аравны дөрөв) хувийг буюу 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны тав) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд байршуулж, Хувьцаа эзэмшигчдийн дансанд дамжуулан олгохоор шийдвэрлэсүгэй.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/04

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын 2025 оны гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 81 дүгээр зүйлийн 81.6.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ЦУХ-26/02 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ–ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаярын 2025 оны үр дүнгийн урамшууллыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаярт олгох, ийнхүү олгохдоо холбогдох хууль тогтоомжид заасан татвар, шимтгэлийг суутгахыг Компанийн Ерөнхий нягтлан бодогч (Ч.Саруултуяа)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/05

Улаанбаатар хот

**Компанийн 2026 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/06

Улаанбаатар хот

Компанийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, бусад арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнээс давсан бусад эх үүсвэрийн санал, Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу Компанийн ТУЗ-өөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Компанийн 2026 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/07

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1, 2.3, 2.5 дахь хэсэг, 3 дугаар бүлэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цагт Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)–ийн 3 давхарт байрлах Juulchin Ballroom танхимд зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - 2.2 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.3 Компанийн ТУЗ–ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 2.4 Компанийн ТУЗ–ийн гишүүдийг сонгох;
 - 2.5 Компанийн ТУЗ–ийн 2026 оны төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”–ийг энэхүү тогтоолын Хавсралт №1–ийн дагуу баталж, “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК–д 2026 оны 02 дугаар сарын 09–ний өдрийн дотор хүргүүлэхийг ТУЗ–ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)–д үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт №2–ын дагуу баталж, 2026 оны 02 дугаар сарын 11–ний болон 27–ны өдрүүдэд Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, мэдээллийн цахим хуудас болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК–ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын

Хавсралт №3-ын дагуу баталж, баримт бичгийг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн дотор бэлтгэн, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасан баримт бичгийг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүртэл Компанийн <https://lend.mn/> вэбсайт болон Компанийн байранд биечлэн ирж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг Компанийн дараах ажилтнуудын бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

М.Түвшинжаргал

Үйл ажиллагааны газрын захирал

Гишүүд:

Х.Хулан
Ц.Хулан
О.Гантулга
Б.Батбилэг
Б.Сарангэрэл
Н.Эрхэмбаяр
Э.Даваахүү

Ж.Батгэрэл
Х.Оюунгэрэл
Э.Хулан
Ц.Оюунбаяр
Б.Цолмон

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
Комплаенсын мэргэжилтэн
Маркетингийн хэлтсийн захирал
Маркетингийн ахлах менежер
Маркетингийн менежер
Ахлах график дизайнер
Мэдээлэл технологийн үйл ажиллагааны албаны менежер
Мэдээллийн технологийн инженер
Харилцагчийн халамжийн хэлтсийн менежер
Хүний нөөцийн менежер
Үйл ажиллагааны менежер
Оффис менежер

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Батбуян

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН,
Партнер

Гишүүд:

М.Маралмаа
Н.Баярмагнай
Д.Шүрэнцэцэг

Хуулийн мэргэжилтэн
Санхүү төлөвлөлтийн албаны ахлах менежер
Санхүүгийн менежер

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудасны дагуу санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Хавсралт №4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт №5а, №5б-ын дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналыг хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
15. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан), Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/08

Улаанбаатар хот

**Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам
батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 болон 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-д нийцүүлэн, Компанийн мөнгөн хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай удирдах зорилтын хүрээнд Компанийн “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-аар баталсугай.
2. Энэхүү тогтоолын Хавсралт №1-аар батлагдсан “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/09

Улаанбаатар хот

**Үнэт цаасны данс нээлгэх,
түүнийг захиран зарцуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах хүрээнд ашиглах үнэт цаасны дансыг “Голомт Капитал ҮЦК” ХХК-д шинээр нээлгэх, тус дансыг Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зориулалтаар ашиглах, захиран зарцуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Голомт Капитал ҮЦК” ХХК-д шинээр үнэт цаасны данс нээлгэх (хүсэлт гаргах, анкет, маягт бөглөх, баримт бичиг гарган өгөх, төлбөр хураамж төлөх, хариу хүлээн авах болон ийнхүү бүртгүүлэхтэй холбоотой бүхий л ажиллагаа хамаарна), түүнийг захиран зарцуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР



**Тооллогын комиссын тайланг
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.11 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “ХЭЭБХ”) -н эчнээ санал хураалтын үр дүнгийн тухай Тооллогын комиссын 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 тоот тайлан болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ”) -ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 25/58 дугаар тогтоолоор ХЭЭБХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан ХЭЭБХ-ын эчнээ санал хураалтаар нийт саналын эрх бүхий хувьцааны 81.16%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч “АНД Системс” ХХК-иас хоёрдогч өглөг хэлбэрээр Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлыг дэмжсэн буюу зөвшөөрсөн санал ирүүлсэн тухай үр дүнгийн тайланг Тооллогын комисс гаргаж Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан болохыг баталгаажуулсугай.
3. Компанийн ХЭЭБХ-ын эчнээ санал хураалтын үр дүнгийн тухай Тооллогын комиссын тайлан, түүнийг үндэслэн гарсан ХЭЭБХ-ын шийдвэр болон холбогдох хууль тогтоомжид заасан бусад баримт бичгийг “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “МХБ”) -д хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.
4. ХЭЭБХ-ын шийдвэрийг МХБ-ийн цахим хуудас, Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, цахим орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийг хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.




**Хоёрдогч өглөгийн хүүгийн нөхцөлийг тогтоож,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулагдсан Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “ХЭЭБХ”)–ын 26/01 тоот шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын 2.2.2 дахь заалт, 3.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АХ-26/02 тоот дүгнэлт болон 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ХЭЭБХ-аар Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор “АНД Системс” ХХК-иас 10,740,000,000 (арван тэрбум долоон зуун дөчин сая) төгрөгийг хоёрдогч өглөг хэлбэрээр авч, Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, тус хоёрдогч өглөгийн хүүг тогтоох, гэрээ байгуулах эрх олгох болон эдгээртэй холбогдон үүсэх бусад асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг Компанийн ТУЗ-д олгосныг дурдсугай.
2. Иймд энэхүү Тогтоолын 1 дэх хэсэгт дурдсаны дагуу “АНД Системс” ХХК-тай байгуулах Хоёрдогч өглөгийн гэрээний хүүг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Компанийн ХЭЭБХ-ын 26/01 тоот шийдвэр болон энэхүү Тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

 _____ Ж.ЖАРГАЛСҮРЭН	 ЛЭНДМН ББСБ ХК Ж.ЖАРГАЛСҮРЭН lendmn УЛААНБААТАР ХОТ 5038754 / 3116267206	 _____ С.БОРГИЛ
 _____ С.НОРГУЙ		_____ Ц.ОДМАА
_____ С.ЭНХ-АМГАЛАН		

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АХ-26/03 тоот дүгнэлт болон 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь LendMN аппликейшн түүний болон дагалдах системүүдийн бүхий л хөгжүүлэлт, засвар, үйлчилгээг хийлгэхээр “АНД Сольюшн” Пти.Лтд-тэй 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдөр 2021/38 тоот “Системийн программ хангамжийн үйлчилгээний гэрээ” байгуулан ажиллаж буйг дурдсугай.
2. “АНД Сольюшн” Пти.Лтд нь өөрийн технологийн үйл ажиллагааны хүрээнд зээлийн скорингийн шийдлийг сайжруулж, цогц систем (цаашид “**Шинэчлэгдсэн скоринг**”)–ийг хөгжүүлсэн бөгөөд Шинэчлэгдсэн скорингийг ашигласнаар Компани нь зээлийн скорингийн моделуудын үйл ажиллагаа болон үзүүлэлтийг тасралтгүй мониторинг хийж, шаардлагатай сайжруулалтыг цаг алдалгүй хийх боломжтой болохыг тэмдэглэсүгэй.
3. “АНД Сольюшн” Пти.Лтд-ийн зүгээс 2021/38 тоот “Системийн программ хангамжийн үйлчилгээний гэрээ”–ний хүрээнд Шинэчлэгдсэн скорингийг Компанид өөрийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг “АНД Системс Тех” ХХК-аар дамжуулан санал болгосныг дурдсугай.
4. Шинэчлэгдсэн скорингийг ашиглах нь Компанийн үйл ажиллагаа, бизнесийн өсөлтөд эерэг нөлөөлөхийн сацуу өөрийн харилцагчдын эрэлт, хэрэгцээнд нь нийцсэн санхүүгийн үйлчилгээг тасралтгүй хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэх тул “АНД Системс Тех” ХХК-ийн зүгээс санал болгосон зээлийн скорингийн цогц системийг ашиглахаар шийдвэрлэсүгэй.
5. Шинэчлэгдсэн скорингийг өөрийн үйл ажиалагаанд авч ашиглахтай холбогдуулан “АНД Сольюшн” Пти.Лтд-тэй байгуулсан 2021/38 тоот “Системийн программ хангамжийн үйлчилгээний гэрээ”–д нэмэлт, өөрчлөлт оруулан одоо ашиглаж буй зээлийн скорингийн үйлчилгээний цар хүрээг хасах эрх, Шинэчлэгдсэн скорингийг ашиглах хүрээнд холбогдох гэрээг “АНД Системс Тех” ХХК-тай шинээр байгуулах эрхийг тус тус Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д олгосугай.
6. Энэхүү тогтоолын 5 дахь хэсэгт заасан Шинэчлэгдсэн скорингийн гэрээ буюу “Кредит скорингийн программ хангамжийн үйлчилгээний гэрээ”–ний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, тус батлагдсан нөхцөлийн дагуу “АНД Системс Тех” ХХК-тай бусад нөхцөлийг тохирч, холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, түүнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д олгосугай.

7. Цаашид энэхүү Тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлцэл хийх, гэрээг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүний үр дүн болон энэхүү Тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ талаар тухай бүр Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.


Ж.ЖАРГАЛСҮРЭН


С.НЭРГҮЙ

_____ С.ЭНХ-АМГАЛАН


С.БОРГИЛ


Ц.ОДМАА



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/13

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Улмаар Компани нь хөрөнгө оруулалтын платформын үйл ажиллагаа эрхэлдэг “KILDE Pte.Ltd.” (цаашид “Kilde” гэх)-аар төлөөлүүлсэн олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид “Санхүүжүүлэгч тал” гэх)-аас нийт 1,000,000 ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилт (цаашид “Санхүүжилт” гэх)-ийг зээлийн гэрээ (цаашид “Зээлийн гэрээ” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
3. Санхүүжилт татан төвлөрүүлэх үйл ажиллагааг баталгаажуулах хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 3.1. Санхүүжүүлэгч тал буюу ALT INCOME INVESTMENTS LMNI PTE.LTD-тэй Зээлийн гэрээ байгуулах;
 - 3.2. Санхүүжүүлэгч талтай байгуулсан Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон ALT INCOME INVESTMENTS PTE.LTD-тэй Барьцааны гэрээ байгуулж, Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулахаар барьцаалуулагчийн үүрэг хүлээх;

(цаашид хамтад нь “Гэрээний багц” гэх)
шаардлагатай байгааг тус тус тэмдэглэсүгэй.
4. Тус тогтоолын 3-т заасан Гэрээний багцыг байгуулах хүрээнд:
 - 4.1. Зээлийн гэрээний нөхцөлийг Хавсралт №1А-д зааснаар баталсугай.
 - 4.2. Барьцааны гэрээний нөхцөлийг Хавсралт №1Б-д зааснаар баталсугай.
5. Тус тогтоолын хавсралтаар батлагдсан Гэрээний багцыг байгуулан Санхүүжилт татан төвлөрүүлэхийг Компанид зөвшөөрсүгэй.
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах,

эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА

Ө.БОЛДБААТАР



**“Супер Ап Хэтэвч” ХХК-ийн
эрх мэдлийн хуваарилалтыг тодорхойлох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.11, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 25/50 тоот тогтоолын дагуу “Супер Ап Хэтэвч” ХХК (цаашид “Охин компани”)–ийг бүхэлд нь худалдан авсан болохыг дурдсугай.
 2. Компанийн ТУЗ-ийн зүгээс тус Охин компанид эзэмшиж буй хувьцааны эрх буюу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчөөр Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–ыг томилсугай.
 3. Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д үүрэг болгосугай.
 4. Компанийн ТУЗ-ийн зүгээс Охин компанийн үйл ажиллагааг төвлөрсөн удирдлагаар хангаж, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх үүднээс:
 - Охин компанийн үйл ажиллагаанд тасралтгүй, үр дүнтэй хяналт тавих;
 - Компанийн хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах;
 - Урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх;
 - Засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг тухай бүр нэвтрүүлэх;
- шаардлага буйг харгалзан Охин компанийн эрх мэдлийн хуваарилалтыг энэхүү тогтоолын Хавсралтад заасны дагуу баталсугай.
5. Энэхүү тогтоолын Хавсралтаар баталсан Охин компанийн эрх мэдлийн хуваарилалтыг үндэслэн Компанийн дүрэм болон холбогдох баримт бичгүүдэд зохих өөрчлөлт оруулж, Хувьцаа эзэмшигчийн шийдвэрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д олгосугай.
 6. Цаашид Охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэн ажиллахдаа энэхүү тогтоолын Хавсралтаар баталсан эрх мэдлийн хуваарилалтад заасан асуудлыг тухай бүр Компанийн ТУЗ-д танилцуулж, зөвшөөрөл авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д даалгасугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувыцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/15

Улаанбаатар хот

“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АХ-26/04 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн охин компани болох “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шонхор үнэлгээ аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ж.Сосор)-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ж.Сосор)-д, толгой компанийн хувьд хяналт тавьж ажиллахыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д тус тус даалгасугай.

